



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/502

Улаанбаатар хот

Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл
мэндийн орон тооны бус салбар зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/502 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2023 оны Б/34 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Баянгол дүүргийн “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах зорилгоор салбар дундын оролцоог ханган ажиллахыг “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөлд”-д даалгасугай.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (С.Мөнхзаяа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Д.ЖАРГАЛСҮРЭН


Баянгол дүүргийн Засаг даргын
2023 оны... дугаар сарын... өдрийн
А/у/а. дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ОРОН ТООНЫ БУС САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- | | | |
|-------------------------|---|--|
| Салбар зөвлөлийн дарга: | - | Засаг дарга |
| Орлогч дарга: | - | Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга |
| Гишүүд: | - | Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга |
| | - | Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| | - | Баянгол дүүргийн Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний хэлтсийн дарга |
| | - | Баянгол дүүргийн Боловсролын хэлтсийн дарга |
| | - | Баянгол дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын
хөгжлийн хэлтсийн дарга |
| | - | Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн
дарга |
| | - | Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн
дарга |
| | - | Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн
Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга |
| | - | Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн
Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга |
| Нарийн бичгийн дарга: | - | Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын
Эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн |

Баянгол дүүргийн Засаг даргын
2023 оны 16 дугаар сарын 22 өдрийн
4/... дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт
243



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ОРОН ТООНЫ БУС САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Баянгол дүүргийн эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл (цаашид “Салбар зөвлөл” гэх)-ийн зохион байгуулалт, чиг үүрэг, холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Салбар зөвлөл нь эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах зорилгоор “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг зохион байгуулна.

Хоёр. Салбар зөвлөлийн чиг, үүрэг

2.1. Салбар зөвлөл нь дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2. Баянгол дүүргийн орон тооны бус салбар зөвлөлийн үндсэн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг орон тооны бус салбар зөвлөлийн дарга удирдаж жилд 2-оос доошгүй /хагас жил тутам/ удаа хийнэ. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг салбар зөвлөлийн дарга эсхүл гишүүдийн олонхын санаачилгаар тухай бүрд зарлан хуралдуулна. Гишүүдийн ирц 50-иас дээш хувь нь болсон тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.3. Орон тооны бус салбар зөвлөлийн дарга хуралдааныг удирдах бөгөөд түүний эзгүйд орлогч дарга түр орлон гүйцэтгэж, орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж ажиллана.

2.4. Орон тооны бус салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэж, хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, дарга хянаж, баталгаажуулна.

2.5. Салбар зөвлөлийн гишүүд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Салбар зөвлөлийн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаанаас бусал тохиолдолд биечлэн оролцох;

- Салбар зөвлөлийн чиг үүрэгт хамаарах асуудлаар санал гаргах, саналаа хуралдаанаар хэлэлцүүлэх

Гурав. Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын чиг үүрэг:

3.1. Баянгол дүүргийн хэмжээнд Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах, эх, хүүхдийн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийг сайжруулах, өсвөр үе, нөхөн үржихүйн

насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр бүх нөөц бололцоог дайчлан ажиллах ба үр дүнг тооцож ажиллана.

3.2. Орон тооны бус салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар хурлын тэмдэглэл гарна. Хуралдаанаас гарсан тэмдэглэлийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудад тухай бүр хүргүүлж, үйл ажиллагааг уялдуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хэрэгжүүлэн ажиллах ба хэрэгжилтэд хяналт тавина.

3.3. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлуулах, гишүүдэд урьдчилж ажлын 5 хоногын өмнө цахимаар болон эсхүл цаасан хэлбэрээр хүргэж танилцуулсан байна.

3.4. Холбогдох тайлан мэдээг нэгтгэх, архивын нэгж бүрдүүлж ажиллана.

3.5. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээ”-ний үйл ажиллагааны үр дүнгийн тайланг хагас бүтэн жилээр нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.